

БНСУ-д удаан хугацаанд оршин сууж буй гадаадын харьяат хүүхдийн сурах эрхийг хамгаалах зорилгоор оршин суух эрх олгох тухай

- БНСУ-д хууль бусаар сургуульд сурч буй гадаадын харьяат хүүхдүүд болон түүний эцэг, эхэд оршин суух эрх олгох үед дараахь нөхцлийг бүрэн хангасан байна.

1 Бүртгүүлэх хугацаа болон хамрагдах нөхцөл

- (Бүртгүүлэх хугацаа) 2022.02.01. ~ 2025.03.31. (Хэрэгжих хугацаа)
- (Хамрагдах хүүхэд) Өргөдөл гаргах үед дараахь ① эсвэл ② нөхцлийг аль нэгийг нь бүрэн хангасан байх.
 - ① ▲БНСУ-д төрсөн эсвэл 6-аас доош насандаа тус улсын хилээр орж ирсэн ▲БНСУ-д 6-аас дээш жил оршин суусан ▲Өргөдөл гаргах үед БНСУ-д бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх эсвэл төгссөн
 - ② ▲БНСУ-д хилээр 6-аас дээш насандаа орж ирсэн ▲БНСУ-д 7-оос дээш жил оршин суусан ▲Өргөдөл гаргах үед БНСУ-д бага, дунд, ахлах сургуульд суралцаж байх эсвэл төгссөн

2 Оршин суух эрх олгох үйл ажиллагаа

- (хүүхэд)
 - ① (Өргөдөл гаргах үед бага, дунд болон ахлах сургуульд суралцаж байгаа тохиолдолд) Ахлах сургууль төгсөх хүртэл хугацаанд суралцах (D-4) ангилалын оршин суух эрх олгоно.
 - ② (Өргөдөл гаргах үед ахлах сургуулиа төгссөн тохиолдолд) ▲Суралцах, ажиллах нөхцлийг

хангаж байгаа тохиолдолд тухайн нөхцөлд нийцсэн оршин суух эрхийг өөрчлөн олгоно. ▲ Суралцах болон ажиллах нөхцлийг хангаагүй тохиолдолд 1 жилийн түр хугацааны оршин суух (G-1) ангилалын оршин суух эрх олгон өөрчлөх.

○ **(Эцэг,эх)** Эцэг эх нь торгуулиа төлсөн тохиолдолд хүүхдийг ахлах сургуулиа төгсөх болон насанд хүрэх хүртэл хугацаанд (G-1) ангилалын оршин суух эрх олгох, хүүхдээ өстөн хүмүүжүүлэх зорилготой бол дээр дурдсан оршин суух ангилалаас гадуур хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох арга хэмжээ авна.

- **(Торгууль ногдуулах)** Хүүхдийн оршин суух зөвшөөрөл хүссэн эцэг эхийг хууль бусаар оршин сууж байгаа үеийн зөрчилд торгууль ногдуулах. *

* Торгууль төлөх чадваргүй, түүнтэй холбоотой шалтгаан байгаа тохиолдолд торгуулийн хэмжээг бууруулах арга хэмжээ авна.

3 Өргөдөл гаргахтай холбоотой бичиг баримтын мэдээллийг:

○ **(Бүрдүлэх бичиг баримт)** БНСУ-ын Хууль зүйн яамны харьяа Цагаачлалын албаны бодлогын хэлтэс (www.immigration.go.kr) болон (www.hikorea.go.kr) сайтнуудаас мэдээлэл авч болно.

○ **(Өргөдөл гаргах)** Өргөдөл хүсэлтээ оршин суугаа газрын харьяа Цагаачлалын албанд гаргана. Хууль зүйн яамны харьяа Гадаадын иргэдийн нэгдсэн зөвлөгөө өгөх төв (Утасны дугаар 1345, орчуулгийн үйлчилгээ үзүүлнэ.)

※ Ажлын цагийн хуваарь 09:00~22:00 (Бямба, ням, бүх нийтийн амралтын өдрүүдэд амрана.), 18 цагаас хойш солонгос, англи, хятад хэлээр зөвлөгөө авч болно.